

## ЭРДЭНЭ РЕСУРС БАЯНХӨНДИЙ АЛТНЫ УУРХАЙН 2026 ОНЫ 1-Р УЛИРЛЫН МЭДЭЭЛЛИЙГ ТАНИЛЦУУЛЛАА

Хэвлэлийн мэдээ  
Нова Скошиа муж, Халифакс хот  
2026.04.20

**Эрдэнэ Ресурс Девелопмент Корп. (TSX:ERD; MSE:ERDN; OTCQB: ERFCF) ("Эрдэнэ Ресурс" эсвэл "Компани")** нь Монголиан Майнинг Корпорэйшн ("ММС")-тэй хамтран эзэмшдэг Эрдэнэ Монгол ХХК ("ЭМ")-ийн хэрэгжүүлж буй Баянхөндий алтны уурхайн ("БХ") 2026 оны 1-р улирлын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэхэд таатай байна. Өөрөөр заагаагүй тохиолдолд энэхүү мэдээнд дурдсан бүх мөнгөн дүнг ам.доллараар илэрхийлсэн.

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал хэлэхдээ, "2026 оны 1-р улиралд Баянхөндий алтны уурхайн боловсруулах үйлдвэр нь 90%-ийн хүчин чадалд хүрч ажилласнаар тогтвортой үйлдвэрлэлийн шатанд шилжлээ. Энэ улиралд алт авалтын дундаж түвшин 96%-аас давж, ТЭЗҮ-д тусгагдсан төсөөллөөс өндөр үзүүлэлттэй байв. Олборлолтын үйл ажиллагаа тогтворжихын хэрээр боловсруулах үйлдвэрийг тэжээж буй хүдрийн агуулга мөн нэмэгдсэн."

"1-р улиралд борлуулалтын хэмжээ олборлолт эхэлсэн эхний улиралтай харьцуулахад 20%-аар өссөн ба өнөөдрийн байдлаар Баянхөндий уурхайгаас нийт 15,961 унц алт үйлдвэрлээд байна."

Тэрээр үргэлжлүүлэн, "Эрдэнэ Ресурс нь 1-р улирлын дундуур эцэслэсэн санхүүжилтийн хүрээнд Хөндий болон Оюу Толгой дүүргүүд дэх суурь болон үнэт металлын төслүүдийг хөгжүүлэхээр ажиллаж байна. Хайгуулын ажил, техникийн судалгаа болон зөвшөөрөлтэй холбоотой үйл явцууд хэвийн үргэлжилж байна."

### Баянхөндий Алтны Уурхай – 2026 оны 1-р улирал

2026 оны 3-р сарын 31-нд дуусгавар болсон улирлын хугацаанд Баянхөндий алтны уурхай нь өдөрт дунджаар 1,675 тонн хүдэр буюу ТЭЗҮ-д танилцуулсан хүчин чадлын 94%-д хүрч, нийт 151 мянган тонн хүдэр боловсруулав.

2026 оны 3-р сарын 31-нд дуусгавар болсон 1-р улиралд боловсруулсан хүдрийн дундаж агуулга 1.9 г/т байсан. Энэ нь тухайн хугацаанд өндөр агуулга бүхий хэд хэдэн бүсэд нэвтрэх боломжийг бүрдүүлэх, уурхайн ажлын түвшинг бэлтгэх зорилгоор бага агуулга бүхий хүдрээр үйлдвэрийг тэжээсэнтэй холбоотой юм. Харин 3-р сард үйлдвэр тэжээх хүдрийн агуулга өсөж, сарын дундаж алтны агуулга 2.7 г/т болсон. Улирлын дундаж алт авалт 96% байсан нь ТЭЗҮ-д тооцоолсон 93%-аас өндөр үзүүлэлт юм.

2026 оны 3-р сарын 31-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд ЭМ нь 8,527 унц алт, 3,135 унц мөнгийг тус тус нэг унцыг нь 4,872 ам. доллар, 80 ам. долларын дундаж үнээр борлуулж, нийт 42 сая ам.доллар (57 сая кан.доллар)-ын орлого төвлөрүүлсэн.

Эрдэнэ Монгол ХХК нь 2-р улиралд олборлолт болон боловсруулалтын үйл ажиллагааг цаашид оновчлон тохируулах ажлыг үргэлжлүүлнэ. Агуулгын хяналт, тэсэлгээ, олборлолт, хүдрийн овоолгын удирдлага, бутлуур болон боловсруулалтын хүчин чадлыг сайжруулснаар төлөвлөсөн дундаж агуулгад хүргэхээр зорьж байна. Уурхайн үйл ажиллагааны хувьд улирлын нөхцөл сайжирсантай холбоотойгоор эерэг нөлөө гарч, 2-р улиралд дээрх ажлуудыг амжилттай хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна. 3-р улиралд

Эрдэнэ Монгол ХХК-ийн ордуудын геологийн нөөц, Баянхөндий болон Хар Морь төслүүдийн үйлдвэрлэлийн нөөцийг шинэчлэн тооцоолж, олборлолтын төлөвлөгөөг шинэчлэхээр ажиллаж байна.



### 2026 оны 1-р улирлын тайлангийн вебкаст

Компанийн удирдлага 2026 оны 3 сарын 31-нд дуусгавар болсон гурван сарын хугацааны аудит хийгдээгүй санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг 2026 оны 5 сарын 6-нд хөрөнгийн бирж хаагдсаны дараа нийтэлнэ. 2026 оны 5 сарын 7-ны өдрийн өглөөний 9:00 цагт (Зүүн эргийн цаг, EST) вебкаст зохион байгуулж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай холбоотой мэдээллийг танилцуулна. Оролцохыг хүсвэл дараах холбоосоор бүртгүүлнэ үү:

### [ВЕБКАСТ](#)

Вебкастын бичлэгийг уг холбоосоор нэг жилийн хугацаанд үзэх боломжтой. Утсаар холбогдон оролцох бол:

- Хойд Америк – төлбөргүй дугаар: (+1) 800 717 1738
- Олон улсын дугаар: (+1) 289 514 5100

## Мэргэшсэн этгээд

Энэхүү хэвлэлийн мэдээнд дурдсан техникийн мэдээллийг компанийн Өсөлт хөгжил хариуцсан захирал Жон Лёнс (FAusIMM) хянан баталгаажуулсан ба NI 43-101-д дурдсан мэргэшсэн этгээд юм.

## Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь өндөр агуулга, бага зардал бүхий Баянхөндий алтны ордын олборлолтоос гадна Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Хөндий Эрдсийн Дүүрэгт байрлах Баянхөндий алтны төслийн орчимд хэд хэдэн үнэт болон суурь металлын төслүүдэд хувь эзэмшдэг. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто (TSX:ERD) болон Монголын хөрөнгийн биржүүд (MSE:ERDN) ба OTCQB Венчур зах зээлд (OTCQB:ERDCD) тус тус бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com)-оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

## Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

*Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.*

**ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.**

## Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал

Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: [info@erdene.com](mailto:info@erdene.com)

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>